



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/297

Хэрлэн сум

**Гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх хэсэг, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/165 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд бүх үхэр, гахайг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 25 хоногт багтаан шуурхай зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд технологит хугацаанд нь гүйцэтгүүлэх, уг ажлын явц, чанарт хяналт тавьж ажиллах аймгийн Онцгой комиссын гишүүдийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, дархлаажуулалтад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг хангуулан, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

4. Дээрх ажилд шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
дугаар сарын 27-ны өдрийн
А/Б/С/Д/Е/... дугаар захирамжийн хавсралт

Малын гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтын ажилд хяналт тавьж, хариуцан ажиллах онцгой комиссын гишүүдийн хуваарь

Д/д	Сумын нэр	Засаг дарга	Хяналт тавьж ажиллах Онцгой комиссын гишүүдийн овог нэр	Албан тушаал
1	Галшар	Д.Нямбаатар Утас:99567878	Г.Мөнх-Эрдэнэ	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
2	Баянхутаг	Б.Амгаланбат Утас: 98636699	Ч.Баярцолмон	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
3	Баянмөнх	Б.Золжаргал Утас: 99278000	О.Баяр-лхагва	Тагнуулын хэлтсийн дарга
4	Дархан	Ж.Энхтөр Утас: 98091117	Б.Сүнгээ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
5	Дэлгэрхаан	Э.Төгөлдөр Утас: 98632196	Ж.Гантулга	Засаг даргын Тамгын газрын дарга
6	Жаргалтхаан	Л.Цэнгэл Утас: 92113175	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга
7	Цэнхэрмандал	С.Золжаргал Утас: 97186060	Э.Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
8	Өмнөдэлгэр	Б.Эрдэнэбаатар Утас: 88092147	Б.Дарханбаатар	Хууль зүйн хэлтсийн дарга
9	Батширээт	Г.Гансүх Утас: 86067052	Л.Цэнддорж	Цэргийн штабын дарга
10	Биндэр	Э.Мөнх-Очир Утас: 97031765	Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга
11	Баян-Адарга	О.Лхагвадорж Утас: 98819081	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
12	Дадал	Д.Мөнх-Од Утас: 93014267	Н.Зоригтбаатар	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
13	Норовлин	А.Мөнхбайгаль Утас: 99665599	Ч.Гантогтох	Онцгой байдлын газрын хошууч
14	Батноров	Б.Жавхланбаяр Утас: 91114371	Л.Өлзийбат	Улаан загалмайн хорооны дарга
15	Баян-Овоо	Д.Баянмөнх Утас: 93191029	Х.Уртнасан	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга
16	Мөрөн	Ц.Батцоож Утас: 98022002	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
17	Хэрлэн	М.Шүрэнцэцэг Утас:92113141	М.Шүрэнцэцэг	Хэрлэн сумын Засаг дарга
18	Бор-Өндөр	Г.Адъяабилэгт Утас: 88887811	Э.Жавхлантөгс	Цагдаагийн газрын дарга